Хавсралт1:

2025-2026 оны хичээлийн жилд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрт бүртгүүлэх арга

БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлэг нь “БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газар болон Монгол Улсын Боловсрол, Шинжлэх ухааны яам хооронд байгуулсан БНХАУ-ын ӨМӨЗО-д монгол оюутан суралцуулах тухай хэлэлцээр” (цаашид “Суралцах хэлэлцээр” гэх)-т үндэслэн, БНХАУ-ын ӨМӨЗО-ны их сургуульд суралцаж эрдмийн зэргийн боловсрол эзэмших Монгол улсын гадаад оюутнуудад олгох тэтгэлэг юм. Монгол улсын гадаад оюутнуудын элсэх нөхцлийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боловсролын удирдах байгууллагууд тогтоох бөгөөд Монгол улсын гадаад оюутнуудын элсэх эрхийг БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боловсролын удирдах байгууллага болон БНХАУ-аас Монгол улсад суугаа Элчин сайдын яам хамтран хянан тогтооно.

Нэг. Элсүүлэх оюутны тоо, төрөл ба тэтгэлгийн хугацаа

Элсүүлэх оюутны тоо: Бакалаврын хөтөлбөрт 200 оюутан, их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бүтэн цагийн магистрын 40 оюутан, бүтэн цагийн докторын 20 оюутан

Тэтгэлгийн хугацаа: Тэтгэлгийн амьжиргааны тэтгэлэг олгох хугацаа зарчмын хувьд манай улсаас тогтоосон үндсэн суралцах хугацаатай ижил байна. Хэрэв тэтгэлэгт тэнцэх үед тэтгэлгийн оюутны хятад хэлний түвшин нь мэргэжил суралцах шаардлагад хүрээгүй бол нэг жилийн хугацаанд бэлтгэл ангид суралцах эсвэл хятад хэл суралцаж болно. Нэг жилийн бэлтгэл ангид суралцсан эсвэл хятад хэл суралцсаны дараа мэргэжил суралцах шаардлагад хүрээгүй оюутан хувийн зардлаар нэг жил дахин суралцана. Хувийн зардлаар дахин нэг жил суралцсаны дараа шаардлагад мөн тэнцэхгүй бол тэтгэлгийн эрхийг хүчингүй болгоно.

Хоёр. Бүртгүүлэгчид тавигдах шаардлага

1. Бүртгүүлэгч нь заавал Монгол улсын иргэн байна.

2. Бие, сэтгэцийн хувьд эрүүл, зан чанар, сурлага сайтай, муу тэмдэглэлгүй эсвэл гэмт хэрэгт холбогдож байгаагүй байх, БНХАУ-ын хилээр орох, гарах нөхцөлд нийцсэн байх

3. Бүртгүүлэгчийн боловсролын болон насны шаардлага:

Бакалаврын зэргээр суралцах өргөдөл гаргагч нь бүрэн дунд боловсрол эсвэл түүнтэй ижил боловсролын зэрэгтэй, онц сайн сурлагын дүнтэй, ерөнхийдөө 25 наснаас хэтрэхгүй байна.

Магистрын зэргээр суралцах өргөдөл гаргагч нь бакалавр зэрэгтэй эсвэл түүнтэй ижил боловсролын зэрэгтэй, онц сайн сурлагын дүнтэй, ерөнхийдөө 35 наснаас хэтрэхгүй байна.

Докторын зэргээр суралцах өргөдөл гаргагч нь магистр зэрэгтэй эсвэл түүнтэй ижил боловсролын зэрэгтэй, онц сайн сурлагын дүнтэй, ерөнхийдөө 40 наснаас хэтрэхгүй байна.

4. Их дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгч нь заавал хятад хэлний түвшин тогтоох шалгалтын 3-р дэс (HSK 3 дэс) болон түүнээс дээш хэлний чадвартай эсвэл холбогдох хэлний түвшинд хүрсэн байх шаардлагатай.

5. Тэтгэлгийн оюутан нь Хятад улсын бүх зэрэглэлийн Засгийн газрын болон сургуулийн бусад тэтгэлгийн(бүх төрлийн нэг удаагийн тэтгэлэг багтаагүй болно) амьжиргааны тэтгэлгийг нэгэн зэрэг авч болохгүй. Амьжиргааны тэтгэлгийг зориудаар нуусан тохиолдолд мэдэгдмэгц ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн эрхийг хүчингүй болгох бөгөөд мөн аль хэдийн авсан ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийг буцаан өгөх ёстой.

Гурав. Бүртгүүлэх арга зам болон бүртгүүлэх хугацаа

Бүртгүүлэх хугацаа 2025 оны 6 сарын 1-ний өдрөөс 30-ны өдөр хүртэл бөгөөд бүртгүүлэгч нь ӨМӨЗО-ны Хятад улсад ирж суралцах гадаад оюутны мэдээллийн систем(туршилт) (https://isms.imu.edu.cn/stu/#/login, цаашид систем гэх)-д бүртгүүлэн өргөдлөө тушаана(дэлгэрэнгүй зааварчилгааг Хавсралт 1-ээс үзнэ үү).

Дөрөв. Бүртгүүлэх материал

Бүртгүүлэгч нь системд доорх материалуудыг үнэн зөв бөглөж, тушаах шаардлагатай. Үүнд:

1. “БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн өргөдлийн хүснэгт”-ийг(хятад эсвэл англи хэлээр бүртгэлийн системд бөглөх)

2. Хүчинтэй гадаад паспортын зурагтай хуудас. Бүртгүүлэгч хүчинтэй хугацаа нь 2026 оны 3 сарын 1-ний өдрөөс хойших өөрийн энгийн гадаад паспортын зурагтай хуудсыг тод сканнердан тушаах шаардлагатай. Хэрэв одоогийн гадаад паспортны хүчинтэй хугацаа нь шаардлагад нийцээгүй тохиолдолд даруй шинэ паспортоор солино уу.

3. Нотариатаар батлуулсан хамгийн дээд боловсролын диплом болон дүнгийн хуудас. Бакалаврын хөтөлбөрт бүртгүүлэгч нь нотариатаар батлуулсан бүрэн дунд боловсролын гэрчилгээ болон дүнгийн хуудсыг тушаах шаардлагатай. Магистрын зэргээр суралцахаар бүртгүүлэгч нь нотариатаар батлуулсан бакалаврын диплом болон дүнгийн хуудсыг тушаах шаардлагатай. Докторын зэргээр суралцахаар бүртгүүлэгч нь нотариатаар батлуулсан бакалавр болон магистрын зэргийн диплом болон дүнгийн хуудсыг тушаах шаардлагатай. Хэрэв бүртгүүлэгч нь суралцаж буй оюутан бол суралцаж байгаа сургуулиас гаргасан Төгсөх магадлагаа эсвэл сурч байгаа тодорхойлолтыг тушаах шаардлагатай. Хятад, англи хэлнээс бусад гадаад хэл дээрх материалын нотариатаар батлуулсан хятад эсвэл англи хэл дээрх орчуулгыг хавсаргана.

4. Хятад улсад ирж суралцах төлөвлөгөө. Бүртгүүлэгч нь хятад эсвэл англи хэл дээр бичсэн Хятад улсад ирж суралцах төлөвлөгөөг тушаах бөгөөд дараах агуулгыг багтаана. Үүнд: Өөрийгөө танилцуулах, Хятад улсад суралцах зорилго, суралцах төлөвлөгөө гэх мэт. Бакалаврын хөтөлбөрт бүртгүүлэгчийн Хятад улсад ирж суралцах төлөвлөгөө 500 үсгээс доошгүй, их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгчийн Хятад улсад ирж суралцах төлөвлөгөө 1000 үсгээс доошгүй байна.

5. “Эрүүл мэндийн шинжилгээний хуудас”(Хятад улсын Эрүүл мэндийн хяналт шалгалтын газраас нэгдсэн байдлаар тогтоосон бөгөөд тушаах үед заавал

хүчинтэй хугацаанд байх ёстой ба заавал хятад эсвэл англи хэл дээр бөглөнө). Бүртгүүлэгч нь “Эрүүл мэндийн шинжилгээний хуудас”-ны шаардлагын дагуу шинжилгээг хийлгэсэн байх хэрэгтэй. Ямар нэгэн шинжилгээ дутуу, цээж зургаа наагаагүй, зурган дээр тамга дарагдаагүй, эмч, эмнэлгийн гарын үсэггүй, тамга дарагдаагүй “Эрүүл мэндийн шинжилгээний хуудас”-ыг хүчингүйд тооцно. Эрүүл мэндийн шинжилгээний хуудас нь 6 сарын хүчинтэй.

6. Гэмт хэрэгт холбогдож байгаагүй тодорхойлолт. Бүртгүүлэгч нь харьяа газрынхаа Цагдаагийн газраас гаргасан хүчинтэй хугацаа бүхий гэмт хэрэгт холбогдож байгаагүй тодорхойлолтыг заавал тушаах хэрэгтэй. Бүртгэлээ тушаах өдрөөс өмнө 6 сарын дотор авсан тодорхойлолт байна.

7. Хувийн бүтээл. Урлаг, дизайн зэрэг төрлийн мэргэжлээр суралцахаар бүртгүүлэгч нь системд “Бусад шаардсан материал”-аар дамжуулан хувийн бүтээлийн төрлийн материалаа оруулна(тухайлбал зураг, уран зураг зэрэг бүтээл).

8. 18 нас хүрээгүй бүртгүүлэгч тэтгэлэгт тэнцсэнийхээ дараа Хятад улсад хууль ёсны асран хамгаалагчийн холбогдох хуулийн бичиг баримтыг сургуульд тушаана.

9. Хэлний чадварын гэрчилгээ. Их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгч нь хятад хэлний түвшингийн шалгалтын 3-р дэс болон түүнээс дээш хэлний чадварын гэрчилгээ эсвэл холбогдох хэлний түвшингийн гэрчилгээний материалыг тушаана.

10. Танилцуулсан захидал. Их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгч нь холбогдох салбарын хоёр дэд профессор болон түүнээс дээш зэрэгтэй албан тушаалтны танилцуулсан захидал, танилцуулагчийн харилцах аргыг хавсаргана. Агуулгын хувьд голчлон бүртгүүлэгчийн Хятад улсад ирж суралцах зорилгын шаардлага, оюутны цогц чадвар, ирээдүйн хөгжлийн талаар үнэлгээ өгсөн байна. Зөвхөн хятад эсвэл англи хэлээр бичигдсэн байна.

11. Оюутан элсүүлэх сургуулийн тушаахыг шаардсан бусад материал. Бүртгүүлэх хөтөлбөр эсвэл мэргэжлээс хамааран өөр бусад шаардлага тавьсан бол дүрмийн дагуу холбогдох материалыг тушаана.

Тав. Суралцах сургууль болон мэргэжлийн сонголт

1. Бүртгүүлэгч нь БНХАУ-ын ӨМӨЗО-ны Боловсролын танхимаас заасан их, дээд сургуулиудын хүрээнд “2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн бакалаврын хөтөлбөрөөр оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт”, “2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн магистрын оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт”, “2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн докторын оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт” (Хавсралт 2,3,4-ийг үзнэ үү)-ын дагуу өөрийн суралцах сонирхолтой нэг сургууль, нэг мэргэжлийг сонгоно. Системийн зарлалын мэдээллийн самбараас оюутан элсүүлэх мэргэжлийн товч танилцуулгыг хайх боломжтой.

Зургаа. Шалгах явц

Бүртгүүлэгч нь бүртгэлийн хугацаанд системд нэвтрэн мэдээллээ бөглөж тушаасны дараа оюутан элсүүлэх сургуулиуд уг системээр дамжуулан оюутны бүртгүүлсэн материалд анхан шатны хяналт шалгалт хийнэ. Анхан шатны хяналт шалгалтад тэнцсэн бакалаврын хөтөлбөрт бүртгүүлэгчийн мэдээллийг Монгол улсын Боловсролын яам руу илгээж, Монгол улсын Боловсролын яамнаас уг системд бүртгүүлэх эрхийг баталгаажуулалт хийж, оюутан элсүүлэх сургуулиуд руу илгээснээр сургуулийн хяналт шалгалтын үе рүү орно.

Их, дээд сургуулийн магистр, докторын хөтөлбөрт бүртгүүлэгчийн тушаасан бүртгэлийн мэдээллийг тухайн сургуулиас хянан шалгаж, ярилцлага эсвэл бичгийн шалгалтыг зохион байгуулж сонгон авах саналаа дэвшүүлнэ.

Долоо. Тэтгэлгийн агуулга болон стандарт

“Суралцах хэлэлцээр”-ийг үндэслэн Хятад улсын тал Монгол улсын гадаад оюутанд дараах тэтгэлгийг олгоно. Үүнд: Сургалтын төлбөр, байрны төлбөр, амьжиргааны тэтгэлэг болон эрүүл мэндийн нэгдсэн даатгалын төлбөр. Бусад зардлыг оюутан өөрөө хариуцна.

Найм. Анхаарах зүйлс

1. Бүртгүүлэгчийн тушаасан мэдээлэл болон материал заавал үнэн бодит, зөв, хүчин төгөлдөр байна. Хэрэв тушаасан мэдээлэл болон материал үнэн бодит, зөв, бүрэн гүйцэд бус шалтгааны улмаас тухайн хүний шалгалт, хяналт эсвэл тэнцэхэд нь нөлөөлсөн бол бүртгүүлэгч үр дагаврыг өөрөө хариуцна. Холбогдох бичиг баримт, материалыг хуурамчаар үйлдсэн, өөрчилсөн, бусдын мэдээллийг ашигласан зэрэг хуурамчаар үйлдэн хууран мэхэлж бүртгүүлсэн эсвэл тэнцсэн бол олж мэдмэгц холбогдох эрхийг хүчингүйд тооцно.

2. Оюутан элсүүлэх сургуулийн хянан шалгах хугацаа ойролцоогоор 7 сарын эхэн үед бөгөөд тодорхой хугацааг оюутан элсүүлэх сургуулийн зарлалаар мөрдлөг болгоно. Сургуулийн хяналт шалгалтын үе рүү орсны дараа сургуулиас бүртгүүлэгчтэй холбогдож шалгалтын холбогдох асуудлыг баталгаажуулна. Бүртгүүлэгч бүртгүүлсэн утасны дугаараа холбоотой байлгаж, и-мэйл хаягаа шуудан хүлээж авахад саадгүй байлгах хэрэгтэй. Утас эсвэл и-мэйлээр холбогдож чадахгүйн улмаас тухайн хүнд зарлах аргагүй тохиолдолд бүртгэлийг автоматаар орхисон хэмээн үзэх болно.

3. Зарчмын хувьд тэнцсэн тохиолдолд оюутан суралцах мэргэжил, суралцах хугацаа, хичээл суралцах хэлийг өөрчилж болохгүй тул сонголтондоо хянамгай хандана уу.

4. Оюутан элсүүлэх сургуулиас тэнцсэн оюутанд Урилга болон “Гадаадын оюутны Хятад улсад ирэх баталгаажуулалтын хүснэгт” (JW202 хүснэгт)зэрэг материалыг өгөх бөгөөд оюутан тус материалуудаар Хятад улсад ирж суралцах визээ мэдүүлнэ.

5. Бүртгүүлэх үед төгсөлтийн дипломын эх хувь, хэлний түвшингийн гэрчилгээ зэргийг дахин шалгах болно. Диплом, гэрчилгээгээ авчраагүй эсвэл шалгалтаар тэнцээгүй тохиолдолд тэтгэлэгт тэнцсэнийг хүчингүйд тооцно.

Ес. Харилцах арга

Өвөр Монголын Их Сургууль ims@imu.edu.cn

Өвөр Монголын Багшийн Их Сургууль lxzsgl@imnu.edu.cn

Өвөр Монголын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль nndgjyzs@163.com

Өвөр Монголын Аж Үйлдвэрийн Их Сургууль gjyoffice@imut.edu.cn

Өвөр Монголын Үндэстний Их Сургууль mdgjjl@imun.edu.cn

Өвөр Монголын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль intl_office@imust.edu.cn

Өвөр Монголын Анагаах Ухааны Их Сургууль immu2021@126.com

Өвөр Монголын Санхүү Эдийн Засгийн Их Сургууль Imufegjy@imufe.edu.cn

Хавсралт:

1. Системийн ажиллагааны зааварчилгаа(оюутны портал)

2. “2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн бакалаврын хөтөлбөрөөр оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт”

3. “2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн магистрын оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт”

4. “2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн докторын оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт”


Хавсралт 1

系统操作指南（学生端）

User Guide for the System (for Students)


1. **访问系统：**浏览器中访问 https://isms.imu.edu.cn/stu/#/login 进入中国内蒙古自治区人民政府奖学金申请系统（试运行）（尽量使用谷歌浏览器，或者 edge 浏览器、360 浏览器极速模式）


Access to the system: visit *https://isms.imu.edu.cn/stu/#/login* to enter Application System for Scholarship of the People’s Government of Inner Mongolia Autonomous Region, China （Trial Operation） (try to use Google browser, or edge browser, 360 browser speed mode).



2. **注册账号：**点击【注册账号】，输入邮箱注册信息，点击【立即注册】


Register an account: Click on [Register an Account], input your email and other registration information, click [Sign Up].






3. **登录账号：**注册完成后，在登录页面输入刚刚设置的账号密码，点击【登录】


Login account: After completing the registration, enter the account and password you just set on the login page and click [LOG IN].





4. **提交申请：**登录成功后，点击【入学申请】，选择招生项目和专业，填写申请信息并上传附件，点击提交即可


Submit the application: After logging in successfully, click on [Start Application], select the Enrollment Project and major, fill in the application information and upload the attachments, then click Submit.



中国内蒙古自治区人民政府奖学金申请系统（试运行）
Application System for Scholarship of the People's Government of Inner Mongolia Autonomous Region, China (Trial Operation)
Language
Admission User Guide
Station Letter
Sign Out
ADMISSIONS SERVICE
Admission User Guide
Each account is intended for personal use only.
Start Application
Name: W Q
E-mail: 1@1.COM
Passport NO.: AA111
Change Password
Notice
See More
May 23 内蒙古工业大学2025/2026学年内蒙古自…
May 23 内蒙古工业大学2025/2026学年内蒙古自…
May 22 内蒙古大学2025/2026学年内蒙古自治区…
Application NO. | English Name | Passport NO. | Major | Application Time | Audit Status | Operation
20250425001 | W Q | AA111 | Theory of Literature and Art | 2025-04-25 09:37:38 | Registration Success | View
20250418002 | W Q | AA111 | Anthropology and World Ethniciti es | 2025-04-18 20:56:46 | Eliminate | View
20250418001 | W Q | AA111 | Economics of Population，Resou rces and Encironmental | 2025-04-18 19:09:11 | Eliminate | View
Copyright @ 2024 The Education Department of Inner Mongolia Autonomous Region All rights Reserved


中国内蒙古自治区人民政府奖学金申请系统（试运行）
Application System for Scholarship of the People's Government of Inner Mongolia Autonomous Region, China (Trial Operation)
Language
Admission User Guide
Station Letter
Sign Out
STEP 1 Enrollment Project
STEP 2 Choose a Major
STEP 3 Application Form
STEP 4 Upload Files
Applying for Schools
Inner Mongolia University-Өвөр Монголын Их Сургууль
Inner Mongolia Normal University-Өвөр Монголын багшийн Их Сургууль
Inner Mongolia Agricultural University-Өвөр Монголын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
Inner Mongolia University of Technology-Өвөр Монголын Аж Үйлдвэрийн Их Сургууль
Inner Mongolia Minzu University-Өвөр Монголын Үндэстний Их Сургууль
Inner Mongolia University of Science & Technology-Өвөр Монголын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
Inner Mongolia Medical University-Өвөр Монголын Анагаах Ухааны Их Сургууль
Inner Mongolia University of Finance and Economics-Өвөр Монголын Санхүү Эдийн Засгийн Их Сургууль
Enrollment Project
Undergraduate Programs
The People's Government Scholarship of the Inner Mongolian Autonomous Region
Graduate Programs (Master)
The People's Government Scholarship of the Inner Mongolian Autonomous Region
Graduate Programs (Ph.D.)
The People's Government Scholarship of the Inner Mongolian Autonomous Region


Application Notes
Application Notification
I hereby affirm that:
1. All information and supporting documentation provided for this application are true and correct. If any falsification or fraud is confirmed, the applicant will be disqualified from admission or expelled if already enrolled.
2. Once admitted, students are not allowed to change major, duration of study, or language of instruction. Please carefully consider your choice of university and major when applying.
3. The university issues "Admission Notice" and "Confirmation Form for Study in China" (JW202) to the students admitted for the purpose of applying for study visa in China. Holders of non-X1 visas will not be permitted to register.
4. Admitted students are required to register in strict accordance with the requirements of the admission notice. The registration time is subject to the requirements of the admission notice.
5. During on-site registration, original certificates (e.g., graduation and language proficiency) must be presented for verification. Those who fail to provide the certificate or fail to pass the certificate examination will be disqualified from admission.
6. Students who fail the physical examination or fail to register on time without permission will have their admission revoked.
7. During my stay in China, I shall abide by the laws and decrees of the Chinese government, and will not participate in any activities in China which are deemed to be adverse to the social order of China and are inappropriate to the capacity as a student.
I confirm that I have read and agree to the above information
Cancel
Next Step
Copyright @ 2024 The Education Department of Inner Mongolia Autonomous Region All rights Reserved



中国内蒙古自治区人民政府奖学金申请系统（试运行）
Application System for Scholarship of the People's Government of Inner Mongolia Autonomous Region, China (Trial Operation)
Language
Admission User Guide
Station Letter
Sign Out
STEP 1 Enrollment Project
STEP 2 Choose a Major
STEP 3 Application Form
STEP 4 Upload Files
Major
Please Enter Major
Disciplines
Please Choose Disciplines
Language
Please Choose Language
Enquire Now
Reset
School
Major
School System
Learning Start Time
Category
Language
Research Direction
Inner Mongolia University
LAW
4 Year
2025-09-01
Doctoral Student
Chinese
Previous
Next Step
Copyright @ 2024 The Education Department of Inner Mongolia Autonomous Region All rights Reserved



中国内蒙古自治区人民政府奖学金申请系统（试运行）
Application System for Scholarship of the People's Government of Inner Mongolia Autonomous Region, China (Trial Operation)
Language
Admission User Guide
Station Letter
Sign Out
STEP 1 Enrollment Project
STEP 2 Choose a Major
STEP 3 Application Form
STEP 4 Upload Files
Basic Information
Study Abroad Plan
Education and Work Background
Other Information
Contact Information
Passport Information
Please fill in the information according to the passport information. If passport name is blank, please fill in with space.
* Surname
Please Enter Surname
* Given Name
Please Enter Given Name
* Passport NO.
Please Enter Passport NO.
* Passport Expiry Date
Please Enter Passport E
Current Location
* Are You in China
Please Choose Are You in
Personal Information
Choose Photo
* Gender
Please Choose Gender
* Nationality
Please Choose Nationality
* Date of Birth
Please Enter Date of Birth
* Country of Birth
Please Choose Country of
* City of Birth
Please Enter City of Bir
* Place of Birth
Please Enter Place of Birth


中国内蒙古自治区人民政府奖学金申请系统（试运行）
Application System for Scholarship of the People's Government of Inner Mongolia Autonomous Region, China (Trial Operation)
Language
Admission User Guide
Station Letter
Sign Out
STEP 1 Enrollment Project
STEP 2 Choose a Major
STEP 3 Application Form
STEP 4 Upload Files
提示 / Notice：请上传有效附件信息，仅上传PDF格式！
Please upload valid attachment information, upload only in PDF format!
*International Passport(page with photo)
Document
*The Notarized Highest Academic Degree Obtained
Document
Other Documents
Document
Previous
Submit
Save Draft
Copyright @ 2024 The Education Department of Inner Mongolia Autonomous Region All rights Reserved

5. **查看申请记录：**提交申请后，页面下方会展示申请数据，点击【查看】即可查看申请信息


View application records: After submitting the application, the application data will be displayed at the bottom of the page. Click [View] to view the application information.






6. **重新编辑：**若提交的申请单被退回，点击【重新编辑】即可更新申请信息并重新提交


Re-edit: If the submitted application form is returned, click [Re-Edit] to update the application information and resubmit.



7. **查看处理意见：**点击【站内信】即可查看处理意见

View review comments: Click on [Station Letter] to view the review comments.





Хавсралт 2

2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн бакалаврын хөтөлбөрөөр оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт

Дэс дугаар	Сургуулийн нэр	Мэргэжлийн нэр
1	Өвөр Монголын Их Сургууль	1. Бизнесийн удирдлага 2. Банк санхүү 3. Нягтлан бодох 4. Эдийн засаг 5. Хятад хэл утга зохиол 6. Хятад хэлний олон улсын боловсрол 7. Сэтгүүл зүй 8. Интернет ба шинэ медиа 9. Хууль эрх зүй 10.Аялал жуулчлалын менежмент 11.Түүх судлал 12. Нийгмийн ажиллагаа 13. Захиргааны менежмент 14. Хөдөлмөр ба нийгмийн хамгаалал 15. Газар шорооны баялгийн менежмент 16.Автоматжуулалт 17. Биологийн шинжлэх ухаан 18. Экологи судлал 19. Байгаль орчны шинжлэх ухаан 20. Инженерийн менежмент 21. Хэрэглээний физик 22. Математик ба хэрэглээний математик 23. Зам тээвэр 24. Зам гүүрийн инженер 25. Логистикийн менежмент 26. Гүн ухаан
2	Өвөр Монголын Багшийн Их Сургууль	1. Газар нутгийн нөөцийн менежмент 2. Газар зүйн шинжлэх ухаан 3.Сэтгүүл зүй 4.Телевизийн найруулга 5.Цахим сүлжээ ба шинэ медиа 6.Аялал жуулчлалын **менежмент** 7. Зочид буудлын менежмент 8.Сэтгэл судлал 9.Орчуулга 10. Дүрслэх урлаг судлал 11.Эдийн засаг 12.Түүх судлал 13. Археологи
3	Өвөр Монголын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	1.Хүнсний шинжлэх ухаан ба инженер 2.Тариалан, ой аж ахуйн эдийн з асгийн менежмент 3.Банк санхүү 4.Цахим худалдаа 5.Нягтлан бодох б үртгэл 6.Амьтан мал эмнэлгийн анагаах ухаан 7. Амьтан судлал 8.Өвс судлал 9.Хөдөө аж ахуйн механикжуулалт, автоматжуулалт 10. Ландшафтын цэцэрлэгжүүлэлт 11.Хөрс хамгаалал, цөлжилтөөс с эргийлэн засах 12.Ухаалаг тээвэр 13.Захиргааны менежмент 14.Ус суд лал, усны нөөцийн инженер
4	Өвөр Монголын Аж Үйлдвэрийн Их Сургууль	1.Барилгын инженер 2.Уул уурхайн инженер 3. Барилгын орчин, эр чим хүчний хэрэглээний 4.Хүрээлэн буй орчны дизайн 5.Бизнесийн удирдлага
5	Өвөр Монголын Үндэстний Их Сургууль	1. Монгол эм зүй 2.Клиник анагаах ухаан 3.Монгол анагаах ухаан 4.Эдийн засаг 5. Олон улсын эдийн засаг болон худалдаа 6.Аялал жуулчлалын менежмент
6	Өвөр Монголын Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль	1. Уул уурхайн инженерчлэл 2.Эрдэс боловсруулах инженерчлэл 3. Онцгой байдлын технологи ба менежмент 4.Барилгын инженер 5.Ар хитектур 6.Хот төлөвлөлт 7.Олон улсын эдийн засаг, худалдаа 8.Мета ллургийн инжнерчлэл 9. Нийгмийн ажил 10.Спортын дасгалжуулагч1 1. Хүрээлэн буй орчны инженер 12.Хүнсний инженерчлэл

7	Өвөр Монголын Анагаах Ухааны Их Сургууль	1.Монгол анагаах ухаан 2.Сувилахуй(монгол анагаах ухааны чиглэлээр) 3.Клиник анагаах ухаан
8	Өвөр Монголын Санхүү Эдийн Засгийн Их Сургууль	1.Олон улсын эдийн засаг ба худалдаа 2.Аялал жуулчлалын менежмент

Хавсралт 3

2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн магистрын оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт

Дэс дугаар	Сургуулийн нэр	Мэргэжлийн нэр
1	Өвөр Монголын Их Сургууль	1.утга зохиол урлаг судлал 2.хэл судлал болон хэрэглээний хэл судлал 3.харьцуулсан утга зохиол болон дэлхийн уран зохиол 4.Хятадын эртний уран зохиол 5.Хятадын орчин үеийн уран зохиол 6.сонин мэдээг түгээн дэлгэрүүлэх судлал 7.Хууль эрх зүй 8.Хэрэглээний эдийн засаг 9.Бизнесийн удирдлага 10.Аялал жуулчлалын менежмент 11.Биологи судлал 12.Экологи судлал 13.байгаль орчны шинжлэх ухаан ба инженер 14.Мэдээлэл болон харилцаа холбооны инженер 15.Хурдан замын байгаль орчны инженер 16.Зам гүүрийн инженер
2	Өвөр Монголын Багшийн Их Сургууль	1.биологи судлал 2.Хэрэглээний математик 3.Судлагдахууны заах арга зүй (математик) 4.Компьютерийн хэрэглээний технологи 5.Антропологи ба дэлхийн үндэстнүүд 6.Нийгэм судлал 7.Антропологи 8.зан үйл судлал 9.Аялал жуулчлалын менежмент 10.Дүрслэх урлаг ба Каллиграф 11.Сургалтын хөтөлбөр ба заах арга зүй 12.Утга Урлагийн ухаан 13.Хятад орчин үеийн уран зохиол 14.Харьцуулсан уран зохиол ба дэлхийн уран зохиол 15.Барууны эдийн засаг 16.Хүн ам, нөөц ба байгаль орчны эдийн Засаг 17.Улс төрийн Эдийн Засаг 18.Сэтгүүл зүй ба харилцаа холбоо 19.Урлаг судлал (кино урлагийн түүх, онол) 20.Байгалийн газар зүй 21.Хүмүүнлэгийн газар Зүй 22.Газрын зураг зүй ба газар зүйн мэдээллийн систем 23.Хүний спортын шинжлэх ухаан 24.Үндэстний уламжлалт спорт судлал 25.Биеийн тамирын боловсрол, дасгалжуулалтын ухаан 26.Улс орны түүх 27.Соёлын өв мэргэжил 28.Музей мэргэжил 29.Олон нийтийн удирдлага

3	Өвөр Монголын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	1.Амьтны генетик үржил ба нөхөн үржихүй 2.Малын шим тэжээл ба тэжээлийн шинжлэх ухаан 3.Өвс судлал 4.Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн эдийн засаг,менежмент 5.Хүнсний шинжлэх ухаан , инженер 6.Мал эмнэлгийн үндэс ухаан 7.Урьдчилан сэргийлэх мал эмнэлэг 8.Хөрс, усны хамгаалал, цөлжилтийн хяналт
4	Өвөр Монголын Аж Үйлдвэрийн Их Сургууль	Барилгын Инженер .1 Архитектур.2
5	Өвөр Монголын Үндэстний Их Сургууль	1.Өвс бэлчээр судлал 2.Тарьмал судлал 3.Аялал жуулчлалын менежмент 4.Үндэстний анагаах ухаан 5.Хятад европ хосолсон клиник 6.Боловсрол судлал

Хавсралт 4

2025-2026 оны хичээлийн жилийн БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ардын засгийн газрын тэтгэлгийн докторын оюутан элсүүлэх сургууль болон мэргэжлийн жагсаалт

Дэс дугаар	Сургуулийн нэр	Мэргэжлийн нэр
1	Өвөр Монголын Их Сургууль	1. Хятадын хэл уран зохиол 2. Хэрэглээний эдийн засаг 3. Нийтийн ажил хэргийн менежмент судлал 4. Биологи судлал 5.Экологи судлал 6.Физик
2	Өвөр Монголын Багшийн Их Сургууль	1.Математик 2. Шинжлэх ухаан, технологийн түүх 3. Байгалийн газар зүй 4. Хүмүүнлэгийн газар зүй 5. Газрын зураг зүй ба газар зүйн мэдээллийн систем 6. Антропологи ба дэлхийн үндэстнүүд 7.Утга, урлагийн ухаан
3	Өвөр Монголын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль	1.Амьтны генетик үржил ба нөхөн үржихүй 2.Өвс судлал 3. Хөдөө аж ахуй, ойн аж ахуйн эдийн засаг, менежмент 4. Хүнсний шинжлэх ухаан, инженер
4	Өвөр Монголын Аж Үйлдвэрийн Их Сургууль	Барилгын .1инженер Архитектур.2
5	Өвөр Монголын Үндэстний Их Сургууль	1. Хятад эм судлал